



Beijing Normal University

Бээжин Багшийн Их Сургууль 1902 онд байгуулагдсан ба 22 сургууль, 6 тэнхим, 38 судалгааны төв, 58 бакалаврын хөтөлбөртэй. Бээжин Багшийн Их Сургууль нь улсын том сургууль төдийгүй дэлхийд танигдсан их сургууль болж, олон улсын оюутнуудад олгодог тэтгэлэг хөтөлбөрүүдийн тоог нэмсэн юм. 2021 байдлаар Хятад улсдаа чансаагаар 22-т бичигдэж байна.

Байршил: Хятад улс, Бээжин хот

Давуу тал:

- Гадаад оюутнуудад олгох тэтгэлэг хөтөлбөрүүд их,
- Тохилор орчин,
- Хятад хэлний босго оноо бага,
- Сургалтын төлбөр хямд .

Санал болгох мэргэжлүүд: Хятад хэл, соёлын сургууль, Хятадын утга зохиолын сургууль, Түүхийн сургууль, Боловсролын сургууль, Гадаад хэл, утга зохиолын сургууль, Урлаг, харилцааны сургууль, Боловсролын технологийн сургууль

Суралцах хугацаа :

Бакалавр 4 жил,
Магистр 2-3 жил (мэргэжлээс хамаарна),
Доктор 5 жил.



Beijing University of Chinese Medicine

Бээжингийн уламжлалт анагаах ухааны их сургууль 1956 онд байгуулагдсан ба хамгийн анхны гадаад оюутан элсүүлэн суралцуулсан сургуулийн нэг юм. БНХАУ -ын Боловсролын Яамны харьяа тус сургууль нь Хятадын уламжлалт анагаах ухааны онцлог шинж чанарыг агуулсан үндэсний гол их сургууль юм. Тус сургууль нь үндсэн мэргэжлээс гадна олон улсын оюутнуудад зориулсан хэлний бэлтгэлтэй ба хятад хэлний түвшин тогтоох HSKшалгалт жил бүр зохион байгуулдаг. 2021 оны Хятадын анагаах ухааны сургуулиудаас чансаагаараа 4т бичигдэж байна.

Байршил: Хятад улс, Бээжин хот

Давуу тал:

- чанартай клиникийнсуурь дадлагатай,
- гадаад оюутнуудыг авьяас чадварын дагуу заах сургалтын загвартай.

Санал болгох мэргэжлүүд:Хятадын уламжлалт анагаах ухааны сургууль, Эм зүйн сургууль, Уламжлалт Европ хосолсон тэнхим.

Суралцах хугацаа:

Бакалавр 4-5 жил,
Магистр 2 жил,
Доктор 3 жил.



Peking University

БЭЭЖИНГИЙН ИХ СУРГУУЛЬ



Beijing Normal University

БЭЭЖИНГИЙН БАГШИЙН ИХ СУРГУУЛЬ



RENMIN University of China

БНХАУ-ЫН АРДЫН ИХ СУРГУУЛЬ



Beijing University of Chinese Medicine

БЭЭЖИНГИЙН УЛАМЖЛАЛТ АНАГААХЫН ИХ СУРГУУЛЬ



Tsinghua University

ЧИНХУА ИХ СУРГУУЛЬ



ADIS MONGOLIA

Чингэлтэй дүүрэг, 3р хороо, энх Тайвны өргөнчөлөө, Пийс таур оффис, 14 давхар

- 1409 тоот

76110765

tom@adismongolia.org



Peking University

Бээжингийн Их Сургууль нь 1898 онд байгуулагдсан ба БНХАУ-ын Боловсролын Яамны харьяа Хятадынорчин үеийн анхны үндэсний иж бүрэн их сургууль юм. ОУ-ын стандартад магадлан итгэмжлэгдсэн 1-р зэрэглэлийн сургууль бөгөөд гадаад оюутнуудад зориулан хэлний бэлтгэл, бэлтгэл ангийн хөтөлбөрүүдтэй. ба 2021 оны байдлаар дэлхийд 16-рт, Ази номхон далайн орнуудад 2-рт жагссан байна.

Байршил: Хятад улс, Бээжин хот

Давуу тал:

- Олон улсад нэр хүндтэй,Хятадын хамгийн том сургууль,
- Олон төрлийн тэтгэлэгт хамрагдах боломжтой.

Санал болгох мэргэжлүүд: Мэдээллийн технологийн сургууль , Хими, молекул инженерийн сургууль,Хот ба хүрээлэн буй орчны сургууль, Сэтгэл судлалын тэнхим, Мэдээллийн менежментийн тэнхим, Хятад хэл, уран зохиолын тэнхим, Олон улсын харилцаа,Урлагийн сургууль

Суралцах хугацаа:

Хэлний бэлтгэл 1 жил ,

Бакалавр 4 жил,

Магистр 2 жил,

Доктор 3-5 жил.



RENMIN University of China

Ардын их сургууль нь 1937 онд анхбайгуулагдсан ба БНХАУ-ын Боловсролын Яамны харьяа Хятадынулсын томоохон иж бүрэн их сургууль юм. Ардын их сургуулийг Хятадын шилдэг улс төрчид хуульчид төгссөн байдаг ба тус сургуулийн профессор багш нар нь Хятадын ШУ-ны салбартаа нэр хүндтэй, нөлөө бүхий судлаачид байдаг. 2021 оны байдлаар Ардын их сургууль Хятад улсад чансаагаараа 6-д жагсаж байна. Одоогоор тус сургуульд 11354 бакалавр, 11149 магистр, 4792 докторант, 1206 гадаад оюутан суралцаж байгаа бөгөөд гадаад оюутнуудад чанартай боловсрол олгох зорилтод хүрэхийн тулд хэлний бэлтгэл ангийн хөтөлбөр , Хятад Англи хэл хосолсон хөтөлбөр хэрэгжүүлж байгаа юм.

Байршил: Хятад улс, Бээжин хот

Давуу тал:

- Улсын том сургууль, олон улсын стандартад нийцсэн MBA гэх мэтхөтөлбөртэй
- Дотуур байрны төлбөр хямд
- Олон төрлийн тэтгэлэгт хамрагдах боломжтой

Санал болгох мэргэжлүүд: Олон улсын харилцааны сургууль, Бизнесийн сургууль, Нийтийн удирдлагын сургууль, Хуулийн сургууль, Сэтгүүл зүйн сургууль

Суралцах хугацаа :

Хэлний бэлтгэл 1-1,5 жил,

Бакалавр 4 жил,

Магистр 2 жил,

Доктор 3-5жил.



Tsinghua University

Чинхуа их сургууль нь анх 1911 онд байгуулагдаж 1978 оноос БНХАУ-ын Боловсролын Яамны харьяа улсын томоохон иж бүрэн судалгааны их сургууль болон хөгжиж, дэлхийд нэртэй, тэргүүний сургууль болсон юм. Чинхуа их сургуулийн магистрантур, докторантурыг жилд 1200 гаруй гадаад оюутан төгсдөг бөгөөд эдгээрийн ихэнх нь Харвард, MIT, Стамфорд, UC-Беркли, Оксфорд, Кембриж зэрэг зэрэг дэлхийд алдартай их дээд сургууль төгссөн байдаг байна. Үүнээс гадна, Чинхуа их сургууль дэвшилтэт судалгаа, оюутан солилцох, хамтарсан судалгаа, хятад хэл судлах, богино хугацааны олон сургалтуудыг зохион байгуулдаг. Гадаад оюутнуудад 18 сургуулийн 38 бакалаврын хөтөлбөрийг санал болгодог. Бакалаврын хөтөлбөрийн архитектураас бусад анги нь 4 жилийн сургалттай, англи, хятад хэлээр хичээллэдэг байна. 2021 оны байдлаар тус сургууль нь дэлхийдчансаагаар 22-т бичигдэж байна.

Байршил: Хятад улс, Бээжин хот

Давуу тал:

- Улсын том сургууль,
- Том хотхон, тохилог анги танхим,
- Олон төрлийн тэтгэлэг зарладаг.

Санал болгох мэргэжлүүд: Физикийн тэнхим, мэдээллийн шинжлэх ухааны тэнхим,Математикийн шинжлэх ухааны тэнхим,инженерийн тэнхим, Эдийн засаг бизнесийн удирдлагын тэнхим , хуулийн тэнхим, сэтгүүлзүйн тэнхим.


Суралцах хугацаа:

Хэлний бэлтгэл 1 жил,

Бакалавр 4 жил,

Магистр 2 жил ,

Доктор 5 жил.





Peking University



**RENMIN University of
China**



Tsinghua University



**Beijing University
of Chinese Medicine**



**Beijing Normal
University**

Хэлний бэлтгэл- 49,000 юань /1 жил/	Хэлний бэлтгэл- 40,000 юань /1 жил/	Хэлний бэлтгэл- 30,000 юань /1 жил/	Хэлний-бэлтгэл- 27,000 юань /1 жил/	Хэлний бэлтгэл- 30,000 юань / 1 жил/
Бакалавр- 26,000-30,000 юань /1 жил/	Бакалавр- 35,000 -45,000 юань /1 жил/	Бакалавр- 24,000-30,000 юань /1 жил/	Бакалавр- 35,000 юань /1 жил/	Бакалавр- 24,000 юань /1 жил/
Магистр- 99,000 юань /2 жил/	Магистр- 45,000 юань /1 жил/	Магистр- 24,000-40,000 юань /1 жил/	Магистр- 45,000 юань / 1 жил/	Магистр- 32,000 юань / 1 жил/
Доктор- 32,000-40,000 юань /1 жил/	Доктор- 45,000 юань /1 жил/	Доктор- 26,000-40,000 юань /1 жил/	Доктор- 47,000юань /1жил /	Доктор- 35,000юань /1 жил/
Дотуур байр- 80 юань 1 хүний өрөө /1 өдөр/	Дотуур байр- 75 юань 2 хүний өрөө / 1 өдөр/	Дотуур байр - 1500 юань /1 жил/	Дотуур байр- 70 юань / 1өдөр/	Дотуур байр- 40 юань / 2 хүний өрөө/ өдөр/
Тэтгэлэг: Бүх түвшинд 100%, 50%, 30%-н тэтгэлэгт хамрагдах боломжтой.	Тэтгэлэг : Бүх түвшинд 50%, 100%- н тэтгэлэгт хамрагдах боломжтой.	Тэтгэлэг : Бүх түвшинд 50% 100%-н тэтгэлэгт хамрагдах боломжтой.	Тэтгэлэг : Бүх түвшинд 50, 100%-н тэтгэлэгт хамрагдах боломжтой.	Тэтгэлэг : Бүх түвшинд 50%, 100%-н тэтгэлэгт хамрагдах боломжтой.